




# ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Дорноговь аймгийн  
нийгэм, эдийн засгийн  
танилцуулга

## ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

### 2018 / 2



Мэдээллийн нэгдсэн лавлах: [WWW.1212.MN](http://WWW.1212.MN)



## **ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**

(2018 оны 02 дугаар сарын байдлаар)

### **Нэг. Нийгмийн үзүүлэлт**




#### **1.1 Хүн ам**

Дорноговь аймгийн хэмжээнд 2018 оны 02 сард 228 эх амаржиж, 228 хүүхэд шинээр мэндэлжээ. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 39(20.6%)-өөр, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 39(20.6%)-өөр, 57 хүн нас барсан нь 8(16.3%)-аар тус тус өссөн байна.

Хүн амын цэвэр өсөлт 171 болж өмнөх оны мөн үеэс 31(22.1%)-ээр өсчээ. 1000 хүнд ногдох төрөлт 3.4, нас баралт 0.8 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.5 пунктээр, нас баралт 0.1 пунктээр тус тус өссөн байна.

*Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2015-2018 оны 02 сард*



Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй бөгөөд нялхсын эндэгдэл 1 байгаа нь өмнөх оны мөн үеэс 2-оор бага байна.



#### **1.2 Эрүүл мэнд**

2018 оны 02 сарын байдлаар 54.5 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 14.0 хувиар, 2,9 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 3,3 хувиар тус тус буурч, 1.9 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар өслөө..


2018 оны 02 сард 277 эх жирэмсний хяналтанд орсны 83.4 хувь буюу 231 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 5.1 пунктээр буурсан байна.

Түргэн тусламжийн дуудлага 3.8 мянган удаа гарсны мянга буюу 15.8 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага 8.6 хувиар өсч, алсын дуудлага адил хэмжээнд байна.



Он гарсаар ослын улмаас 485 хүн бэртэж, 10 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 62 (14.7%)-оор нэмэгдэж, нас барсан хүний тоо 4 (28.6%) хувиар буурсан байна.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2018 оны 02 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд хавдар 32.0 хувь, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 30.0 хувь, амьсгалын тогтолцооны өвчин 9.0 хувь, осол гэмтэл, хордлого гадны шалтгаант нас баралт 17.0 хувь, бусад төрлийн өвчин 12.0 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 99 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 77(43.7%)-оор буурчээ. Халдварт өвчний тохиолдол буурахад сүрьеэ 13.3 хувь, трихоминиаз 52.4 хувь, тэмбүү 27.8 хувь, бусад төрлийн өвчин 81.8 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.




### 1.3 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2018 оны 02 сарын эцэст 1040 болсны 1029 (98.9%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 11 (1.1%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 665 (39.0 %) хүнээр буурч, өмнөх сараас 15(1.5%) хүнээр өссөн байна. Бүртгэлтэй ажил хайгч иргэдийн 522 (50.2%) нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 527 (50.7%) нь Сайншанд суманд, 228 (21.9%) нь Замын-Үүд суманд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 55.6 хувь нь бүрэн дунд, 22.8 хувь нь дээд, 7.7 хувь нь техник болон мэргэжлийн, 5.7 хувь нь бүрэн бус дунд, 5 хувь нь тусгай дунд, 1 хувь нь бага, 1.9 хувь нь боловсролгүй, 0.4 хувь нь магистр/докторын боловсролтой иргэд эзэлж байна.


Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2018 оны 02-р сард



Хөдөлмөрийн хэлтэст он гарсаар 348 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 15 иргэн ажилд зуучлагдан орж, 72 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна

Хөдөлмөрийн хэлтэст ирсэн 16 ажлын байрны 6(37.5%) нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын захиалга байна. Ажил хайгч 15 иргэн хөдөлмөрийн байгууллагаар дамжуулан ажилд зуучлуулан орсны 10 (66.7%) нь эмэгтэйчүүд байна

Зураг. Бүртгээгүй ажилгүй иргэд сумаар



Зураг. Шинээр ажлын байранд орсон иргэд салбараар



Графикийг үсгийн ф




#### 1.4 Нийгмийн даатгал, халамж

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 02 сард 4832.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 871.3 (22.0%) сая төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 02 сард өмнөх оны мөн үеэс 871.3 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 576.0(23.4%)




сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сан 150.6(43.0%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгал 73.1(2.1 дахин) өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2018 оны 02 сард



Нийгмийн даатгалын сангийн зарлага 7023.2 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 1494.3 (27.0%) сая.төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 5076.0(72.3%) сая.төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 360.7(5.1%) сая.төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 1139.9(16.2%) сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 330.7(4.7%) сая.төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 115.9(1.7%) сая төгрөгийг зарцуулжээ.

Зураг. Нийгмийн даатгалын зарлага, сая төг




Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээгээр нийгмийн халамжийн сангаас 2018 оны эхний 02 сард нийгмийн халамжийн сангаас 17031 иргэнд 1648.1 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд 6317 (59.0%)-өөр, олгосон тэтгэвэр тэтгэмж 516.2 (45.6%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Халамжийн тэтгэвэр, тэтгэмж өсөхөд насны хишиг, цалинтай ээж хөтөлбөрт 5167(30.3%)




иргэнд 437.7(26.6%) сая төгрөгийн тэтгэмж олгосон нь нөлөөлсөн байна. Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2018 онд 1220 хүн хамрагдсан нь өмнөх оноос 177 (17.0%)-ээр, олгосон тэтгэвэрийн хэмжээ 95.8 (37.9%) сая төгрөгөөр нэмэгджээ. Нийгмийн нөхцөлт мөнгөн тусламжид 921 иргэнд 117.1 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 292 иргэнд 77.1 сая төгрөг тус тус олгож, нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургахад 5444 иргэнд хамруулж 125.5 сая төгрөгийг зарцуулсан байна. Нийгмийн бусад халамжийн шаардлагатай иргэнд үзүүлэх тусламжийг 9154 иргэнд 979.8 сая төгрөг олгосон байна.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /мян төг/



### 1.5 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр оны эхний 02 сарын байдлаар 100 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 20 хүн гэмтэж, 6 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 28(21.9%)-аар, нас барсан хүний тоо 4 (40.0%)-өөр, гэмтсэн хүний тоо 18(47.4%) -аар буурсан байна.




Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хүний амины гэмт хэрэг 3 (30.0%)-аар, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 14 (40.0%)-өөр, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 8(17.4%)-аар, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчсөн гэмт хэрэг 3 (30.0%)-аар буурч, авилгын гэмт хэрэг, цэргийн албаны эсрэг гэмт хэрэг, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 38(38.0%) хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 21(21.0%) хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 9(9.0%) хувийг улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг, 32.0 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна. Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 10 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27(72.9%) -оор буурсан байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Айраг, Алтанширээ, Өргөн, Сайхандулаан, Хатанбулаг, Сайншанд, Замын-Үүд сумдад буурч, Иххэт, Мандах, сумдад өмнө онтой адил, Хөвсгөл суманд гэмт хэрэг бүртгэгдээгүй байна. Даланжаргалан, Дэлгэрэх, Эрдэнэ сумдад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 1-ээр нэмэгдсэн мэдээ гарчээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар




Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 63.1 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 857.3 (93.1) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 43.5 (68.9%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 28 (28.0%) нь гэр сууцандаа, 11 (11.0%) нь гудамж олон нийтийн газарт, 10(10.0%) нь согтуугаар, 7 (7.0%) бүлэглэн, 5 (5.0%) хувийг эмэгтэй хүн, хүүхэд оролцон, 37, (37.0%) нь орой, шөнийн цагаар /22.00-06.00 цаг/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 187 хүн эрүүлжүүлэгдэж, 45 хүн баривчлагджээ.



Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 02 сард




### Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт




#### 2.1 Мөнгө, зээл

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын кассын орлого 202.5 тэрбум төгрөг болж өмнөх оноос 18.2(9.9%) сая төгрөгөөр, цэвэр зарлага 232.9 тэрбум төгрөг болж 53.4(29.8%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2017- 2018 он, мян.хүн



Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2017-2018 он, сая.төг






Иргэдийн мөнгөн хадгаламж 81.8 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 1210.3 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 1199.7 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хадгаламж эзэмшигчийн тоо 1.0 (1.5%) мянган хүнээр, хадгаламжийн үлдэгдэл 17.4 (27.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна.


Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 02 дугаар сарын эцэст 4291.4 сая төгрөг болж, өмнөх сараас 553.8(14.8%) сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 1504.2 (54.0%) сая төгрөгөөр нэмэгджээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.0 хувийг эзэлж, өмнөх сараас 0.2 пунктээр, өмнөх оны мөн үеэс 0.5 пунктээр нэмэгджээ.

Чанаргүй зээл 02 дугаар сарын эцэст 6929.6 сая төгрөг болж өмнөх сараас 20.7 (0.3%) сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 1251.9 (15.3%) сая төгрөгөөр буурсан. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.2 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.2 пунктээр буурсан байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2018.02 сард




Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2018.02 сард



## 2.2 Орон нутгийн төсөв

2018 оны 02 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 3526.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 115.1 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 36.6 хувиар өссөн байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 84.1 хувийг татварын, 15.9 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2018 оны 02-р сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр нийт 634.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 176.2(38.4%) сая.төг-өөр нэмэгдэж, тухайн оны төлөвлөгөөнөөс 146.7(30.1%) сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



### 2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.


Хэрэглээний үнийн индекс 2018 оны 02 дугаар сард өмнөх сараас 1.5 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар өсчээ.

**Ерөнхий индекс өмнөх сараас 1.5 хувиар өсөхөд:** хүнсний бараа, ундаа усны бүлэг 4.8 хувь, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодисын бүлэг, 0.2 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 0.2 хувь, тээвэр 2.6 хувь,бусад бараа, үйлчилгээний бүлэг 0,5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018 оны 02 дүгээр сарын өөрчлөлт, өмнөх сартай харьцуулсанаар (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018 оны 02 дугаар сарын өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)



### Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт



#### 3.1 Хөдөө аж ахуй

Оны эхний 2 сарын байдлаар төллөвөл зохих эх малын 1.3 хувь буюу 11.2 мянган толгой мал төллөж, төл бойжилт 99.7 хувьтай байна. Өмнөх оны мөн үеийнхээс төллөсөн хээлтэгч 9.4 (6.3 дахин) мянган толгойгоор, төл бойжилт 9.5 (6.3 дахин) мянган толгойгоор илүү юм.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн судалгаагаар Сайншанд суманд 02-р сард ноолуурын дундаж үнэ 70000 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 25000 (64.3%) төг-өөр өссөн байна. Харин ингэний сүү 2500 төг, тэмээний шир 20.0 мянган төгрөг, адууны шир 15.0 мянган төгрөг, ямааны арьс 32.0 мянган төг-ийн ханштай байна. Эр хонь 100.0-180.0 мян.төг, эр ямаа 60.0-150.0 мян.төг-өөр худалдаалагдаж байна.



#### 3.2 Аж үйлдвэр

Оны эхний 02 сард аж үйлдвэрийн салбарт 10098.9 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 18890.6 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 23.7 хувиар өсч, борлуулалт 13.3 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 13.6 хувийг төрийн, 86.4 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 13.6 хувь, компани 85.3 хувь, өрхийн аж ахуй 1.1 хувийг тус тус эзэлж байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй сувагжуулалт 12.4 мян.м3-ээр, нарийн боов 2.7 тонноор, бялуу 0,4 тонноор, цэвэр ус 12.0 мян.литрээр, вакуум цонх 634.1 м2-аар, модон эдлэл 10365.0



мян.төгрөгөөр, дээл 128 ширхэгээр, жижиг оёдол 10365.0 мян.төгрөгөөр, тус тус илүү үйлдвэрлэгджээ.

## Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



### 4.1 Байгаль орчин Цаг уур

2018 оны 02 дугаар сарын дундаж агаарын температур нутгийн өмнөд хэсгээр 9.3-210.6 хэм хүйтэн, бусад нутгаар 11.8-14.7 хэм хүйтэн, агаарын хамгийн их температур өдөртөө Хатанбулаг суманд 11 хэм дулаан, Иххэт суманд 1 хэм хүйтэн, бусад сумдын нутгаар 2-8 хэм дулаан байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж / ОЖД /-тай харьцуулахад: Улаанбадрах, Замын-Үүд, Өргөн, Айраг сумдад ОЖД-аас 1.3-2.6 хэмээр дулаан, бусад сумдын нутгаар ОЖД-ийн орчим байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө 26-33 хэм хүйтэн, өдөртөө Дэлгэрэх, Иххэт сумдад 14-15 хэм дулаан, бусад сумдын нутгаар 19-26 хэм дулаан байв.

2 дугаар сард нийт сумдын нутгаар 2-5 өдөр хур тунадастай байж, 0.0-1.2 мм хур тунадас орлоо.

Энэ сард нийт нутгаар салхины хамгийн их хурд секундэд 12-18 метр хүрсэн. 10м/с-ээс дээш салхитай хоногийн тоо Сайншанд суманд 18, Мандах суманд 13, Замын-Үүд, Дэлгэрэх сумдад 12, Эрдэнэ, Хөвсгөл сумдад 10-11, бусад сумдын нутгаар 2-8 өдөр байлаа.

\_\_\_\_\_ о Оо \_\_\_\_\_



## АГУУЛГА

### II. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдлын тухай статистикийн тоон мэдээлэл (Эдийн засгийн үйл ажиллагааны ангиллаар)

#### Нэг. Эрүүл мэнд

- 1.1 Эрүүл мэнд
- 1.2 Төрөлт, эх хүүхдийн эндэгдэл, сумаар
- 1.3 Халдварт өвчний гаргалт, сумаар

#### Хоёр. Хөдөлмөр эрхлэлт

- 2.1 Ажилгүй иргэдийн тоо, боловсролын түвшингээр
- 2.2 Ажилгүй иргэдийн тоо, сумаар
- 2.3 Ажлын байрны захиалга, эдийн засгийн салбарын ангилалаар
- 2.4 Ажлын байрны захиалга ажил мэргэжлийн ангилалаар
- 2.5. Ажилд зуучилсан иргэд, ажил мэргэжлийн ангилалаар
- 2.6. Шинэ ажлын байранд орсон иргэн, эдийн засгийн салбарын ангиллаар

#### Гурав. Нийгмийн даатгал, халамж

- 3.1 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, төрлөөр
- 3.2 Нийгмийн даатгалд заавал даатгуулагчийн тоо, олгосон тэтгэврийн хэмжээ
- 3.3 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ

#### Дөрөв. Гэмт хэрэг

- 4.1 Бүртгэгдсэн хэргийн тоо төрлөөр, аймгийн дүнгээр
- 4.2 Бүртгэгдсэн хэргийн тоо сумаар

#### Тав. Мөнгө, зээл

- 5.1 Мөнгөн гүйлгээ, зээл
- 5.2 Хадгаламж, зээл, сумаар, 7 сарын эцэст

#### Зургаа. Орон нутгийн төсөв

- 6.1 Орон нутгийн төсвийн орлого, сая төгрөгөөр
- 6.2 Орон нутгийн төсвийн зарлага, сая төгрөгөөр
- 6.3 Орон нутгийн төсвийн орлого, зарлага, сумдаар, сая төгрөгөөр
- 6.4. Улсын нэгдсэн төсөвт төвлөрүүлсэн орлого, сая төгрөгөөр

#### Долоо. Үнэ

- 7.1 Хэрэглээний үнийн индекс
- 7.2 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф
- 7.3 Гол нэрийн барааны үнэ, хөрш зэргэлдээ аймгуудаар

#### Найм. Хөдөө аж ахуй

- 8.1 Мал төллөлт, төл бойжилт
- 8.2 Том малын зүй бус хорогдол
- 8.3 ХАА-н бүтээгдэхүүний үнийн судалгаа, төрлөөр
- 8.4 Малын үнийн судалгаа, сумаар

#### Ес. Аж үйлдвэр

- 9.1 Нийт бүтээгдэхүүн, борлуулалт, оны үнээр
- 9.2 Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн жигд ажиллагаа
- 9.3 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дэд салбараар
- 9.4 Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сумаар, нийт бүтээгдэхүүн гол нэр төрлөөр

#### Арав. Байгаль орчин

- 10.1 Цаг уурын үзүүлэлт

#### Тэмдэглэлийн тайлбар :

- ( ,, ) - тухайн тоо, баримт байхгүй
- ( 0 ) - тайлант хугацаанд гүйцэтгэлгүй
- ( х ) - энэ хүснэгтэнд тоо нөхөгдөхгүй
- ( . ) - мэдээлэгдэх хугацаа болоогүй

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**  
( 2018 ОНЫ 2 ДУГААР САРЫН БАЙДЛААР )

**I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд**

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015	2016	2017	2018	2018 - 2017	2018
							хувь
1. Бэлэн хүн ам	мянган хүн	63.1	66.6	68.2	68.4	0.2	100.3
- Төрсөн хүүхдийн тоо*	тоо	238	249	189	228	39	120.6
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	45	62	49	57	8	116.3
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	193	187	140	171	31	122.1
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	2	2	3	1	-2	33.3
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	8.4	8.0	15.9	4.4	-11.5	27.6
2. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	114	352	176	99	-77	56.3
- 10000 хүнд ногдох	тоо	17.9	54	26	15	-11	56.3
3. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	1 272	1 340	1 705	1 040	- 665	61.0
- Үүнээс эмэгтэй	тоо	778	761	889	522	- 367	58.7
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	32	32	39	24	- 15	61.0
4. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	22	28	56	3	-53	5.4
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	20	28	56	3	-53	5.4
Улирлын чанартай ажлын байр	тоо	2	0	0	0	0	
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	60	49	76	100	24	131.6
- 10000 хүнд ногдох ***	тоо	14	12	18	23	5	130.8
6.Бойжиж буй төл, мян толгой	толгой	150	21496	587	11255.0	10668	1917
- Унага	толгой	0	1984	1	8.0	7	800
- Тугал	толгой	11	1925	2	130.0	128	6500
- Ботго	толгой	1	9	0	24.0	24	
- Хурга	толгой	57	7423	569	6895.0	6326	1212
- Ишиг	толгой	81	10155	15	4198.0	4183	
7. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	3039.5	3152.5	8166.8	10098.9	1932.1	123.7
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	2423.5	2201.7	21787.0	18890.6	-2896.4	86.7

\* - 2015, 2016, 2017 оны жилийн эцэст

\*\* - Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

\*\*\* - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.



## II. ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА

## НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

## 1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 02 сарын эцэст

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 I-II	2018 I-II	Өсөлт	
		Тоо			хувь
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	63.4	54.5	-8.9	86.0
2. Ор хоног	мян.хүн	21.1	20.5	-0.6	97.2
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	1.8	1.9	0.1	105.6
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	3.0	2.9	-0.1	96.7
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	3.5	3.8	0.3	108.6
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	0.6	0.6	0	100.0
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	423	485	62	114.7
Үүнээс: нас баралт	хүн	14	10	-4	71.4
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	253	277	24	109.5
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	224	231	7	103.1
8. Амаржсан эх	хүн	189	228	39	120.6
Үүнээс: нас баралт	хүн	0	0	0	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	0	1	1	0.0
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	3	1	-2	33.3

## 1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн эхний 02 сарын эцэст

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1	1-5
				хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүртэл насны эндсэн хүүхэд
Тоо					
Дүн	228	0	228	1	1
Айраг					
Алтанширээ					
Даланжаргалан					
Дэлгэрэх					
Иххэт					
Мандах					
Өргөн					
Сайхандулаан					
Улаанбадрах					
Хатанбулаг	1		1		
Хөвсгөл	0				
Эрдэнэ	1		1		
Сайншанд	191		191		
Замын - Үүд	35		35	1	1

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар

1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн эхний 02 сарын эцэст

Үзүүлэлт	2016 I-II	2017 I-II	Өсөлт	
	Тоо		Хувь	
Халдварт өвчний гаралт-Бүгд	176	99	-77	56.3
Вируст гепатит	3	0	-3	0.0
Сүрьеэ	15	13	-2	86.7
Тэмбүү	18	13	-5	72.2
Заг хүйтэн	18	41	23	227.8
Трихоминиаз	21	10	-11	47.6
Цусан суулга	2	4	2	200.0
Бусад	99	18	-81	18.2

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар



*Нийгэм, эдийн засгийн байдлын танилцуулга*  
**ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ**

2.1 БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 2 сарын эцэст

Боловсролын түвшингээр	2015. II	2016. II	2017. II	2018. II	$\frac{2018. II}{2015. II}$	$\frac{2018. II}{2017. II}$
	хүний тоо				хувь	
ДҮН	1 272	1 340	1 705	1 040	81.8	61.0
Үүнээс: Эмэгтэй	778	761	889	522	67.1	58.7
Магистр, доктор	4	10	7	4	100.0	57.1
Дээд боловсролтой	369	339	415	237	64.2	57.1
Тусгай дунд	120	174	180	52	43.3	28.9
Техник мэргэжлийн	94	149	166	80	85.1	48.2
Бүрэн дунд	400	474	706	578	144.5	81.9
Бүрэн бус дунд	223	151	189	59	26.5	31.2
Бага	50	34	33	10	20.0	30.3
Боловсролгүй	12	9	9	20	166.7	2.2 <sup>2</sup>

2.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 2 сарын эцэст

	Ажилгүй иргэдийн тоо		Ажилд орсон хүний тоо		Шинээр бүртгүүлсэн хүний тоо	
	2017. II	2018. II	2017. II	2018. II	2017. II	2018. II
ДҮН	1705	1040	74	15	202	348
Айраг	200	14	23	6	24	33
Алтанширээ	21	29	2	0	8	22
Даланжаргалан	60	47	1	0	7	6
Дэлгэрэх	47	22	8	0	22	4
Иххэт	41	44	0	1	0	4
Мандах	95	15	0	1	0	13
Өргөн	73	39	4	1	23	0
Сайхандулаан	47	13	1	0	7	2
Улаанбадрах	32	8	2	0	1	11
Хатанбулаг	46	31	2	0	3	13
Хөвсгөл	32	11	12	0	13	3
Эрдэнэ	27	12	3	0	8	13
Сайншанд	717	527	12	5	66	124
Замын - Үүд	267	228	4	1	20	100

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

2.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал, 02 сарын эцэст

Салбарын ангилал	2017. II	2018. II
	Тоо	
Бүгд	123	16
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт	8	2
Уул уурхай олборлох аж үйлдвэр	33	3
Боловсруулах үйлдвэрлэл	0	
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0	1
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0	
Барилга	1	
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	0	
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	0	
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	0	
Мэдээлэл, холбоо	0	
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1	
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0	
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	0	
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0	
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	23	1
Боловсрол	9	2
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	8	1
Урлаг, үзвэр, тоглоом наадам	3	
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	37	6
Хүн хөслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн нэр төрлөөр нь салгаж тодорхойдох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ	0	
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0	

2.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал, 02 сарын эцэст

Үзүүлэлт	2017. II	2018. II
	Тоо	
Бүгд	123	16
Менежер	5	
Мэргэжилтэн	34	3
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	6	1
Контор, үйлчилгээний ажилтан	8	3
Худалдаа, үйлчилгээний ажилтан	27	4
ХАА, ой загас агнуурын ажилтан	0	2
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	4	
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, үгсрагч	16	
Энгийн ажил мэргэжил	21	3
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	2	

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



## 2.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангилалаар 02 сарын эцэст

Үзүүлэлт	2017. II		2018. II	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
	тоо		тоо	
Бүгд	98	53	15	10
Менежер	5	1		
Мэргэжилтэн	19	16	4	4
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	4	4	1	1
Контор, үйлчилгээний ажилтан	6	5	3	3
Худалдаа, үйлчилгээний ажилтан	21	13	4	2
ХАА, ой загас агнуурын ажилтан	0	0		
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	4	0		
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	19	5		
Энгийн ажил мэргэжил	19	8	3	
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	1	1		

## 2.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, эдийн засгийн салбарын ангиллаар 02 сарын эцэст

Салбарын ангилал	Бүгд	Эмэгтэй	Бүгдээс: Ажлын байрны шинж, чанараар	
			Байнга	Улирал
	тоо			
Бүгд	3	1	3	0
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1	0	1	
Уул уурхай олборлолт				
Боловсруулах үйлдвэрлэл				
Цахилгаан, хий уур агааржуулалтын хангамж				
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент				
Барилга				
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	1	1	1	
Тээвэр агуулахын үйл ажиллагаа				
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа				
Мэдээлэл холбоо				
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа				
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа				
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа				
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа				
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	1		1	
Боловсрол				
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа				
Урлаг үзвэр тоглоом наадам				
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа				
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй				
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа				

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



## ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

## 3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА төрлөөр, жил бүрийн 2 сарын эцэст

Үзүүлэлт	Олгосон тэтгэвэр тэтгэмж		<u>2018 I-II</u>
	2017 I-II	2018 I-II	2017 I-II
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	3 960.8	4 832.1	122.0
Үүнээс: Тэтгэврийн даатгалын сангийн	2 462.4	3 038.4	123.4
Тэтгэмжийн даатгалын сангийн	278.2	343.8	123.6
Эрүүл мэндийн даатгалын сангийн	805.1	811.1	100.7
ҮОМШӨ-ний даатгалын сангийн	350.3	500.9	143.0
Ажилгүйдлийн даатгалын сангийн	64.8	137.9	2.1 <sup>2</sup>
Нийгмийн даатгалын сангийн зарлага	5 528.9	7023.2	127.0
Үүнээс: Тэтгэврийн даатгалын сангийн	4 480.1	5 076.0	113.3
Тэтгэмжийн даатгалын сангийн	264.0	360.7	136.6
Эрүүл мэндийн даатгалын сангийн	411.2	1 139.9	2.8 <sup>2</sup>
ҮОМШӨ**-ний даатгалын сангийн	192.9	330.7	171.4
Ажилгүйдлийн даатгалын сангийн	180.7	115.9	64.1

\*\* - ҮОМШӨ- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

## 3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ЗААВАЛ ДААТГУУЛАГЧДЫН ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 2 сарын эцэст

Үзүүлэлт	ХЭМЖИХ НЭГЖ	2017 I-II	2018 I-II	<u>2018 I-II</u> 2017 I-II
1. Заавал даатгуулагч хүний тоо	тоо	11995	13202	110.1
Үүнээс: Аж ахуй нэгж, байгууллага	тоо	5812	6496	111.8
Төсөвт байгууллага	тоо	6183	6706	108.5
2. Олгосон тэтгэвэр	сая төгрөг	4620.5	5218.7	112.9
Үүнээс: Өндөр насны тэтгэвэр	сая төгрөг	3447.6	3833.9	111.2
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн тэтгэвэр	сая төгрөг	475.9	549.1	115.4
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	сая төгрөг	236.1	249.4	105.6
ҮОМШӨ-ний даатгалын сангийн тэтгэвэр	сая төгрөг	142.4	143.9	101.1
Цэргийн тэтгэвэр	сая төгрөг	318.5	442.4	138.9

Эх үүсвэр: Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс



## 3.3 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 02 сарын эцэст

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2018 I- II	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2018 I- II
	2017 I-II	2018 I-II	2017I- II	2017 I- II	2018 I-II	2017I- II
	тоо		хувь	мянган төгрөг		хувь
<b>НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ</b>	<b>10714</b>	<b>17031</b>	<b>159.0</b>	<b>1131987.6</b>	<b>1648143.9</b>	<b>145.6</b>
<b>1. Халамжийн тэтгэвэр</b>	<b>1043</b>	<b>1220</b>	<b>117.0</b>	<b>252975.9</b>	<b>348732.9</b>	<b>137.9</b>
Ахмад настны тэтгэвэр	44	53	120.5	10733.3	13653.5	127.2
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	999	1167	116.8	242242.6	335079.4	138.3
<b>2 Нөхцөлт мөнгөн тэтгэмж</b>	<b>877</b>	<b>921</b>	<b>105.0</b>	<b>91663.7</b>	<b>117084.2</b>	<b>127.7</b>
Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч	817	862	105.5	85579.4	109377	127.8
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	48	47	97.9	4682.7	6560.3	140.1
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	3	6	2.0 <sup>2</sup>	256.0	524.0	2.0 <sup>2</sup>
Ахмад настныг гэртээ асрамжилж байгаа иргэн	0	5		0.0	558.9	
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн	9	1	11.1	1145.6	64.0	5.6
<b>3. Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн</b>	<b>332</b>	<b>292</b>	<b>88.0</b>	<b>87215.6</b>	<b>77085.5</b>	<b>88.4</b>
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	300	208	69.3	79275.6	58865.5	74.3
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	2	74	37.0 <sup>2</sup>	60.0	4620.0	77.0 <sup>2</sup>
Гурав ба түүнээс дээш тооны бага насны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/	26		0.0	2280.0		0.0
2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	1	2	2.0 <sup>2</sup>	2000.0	4000.0	2.0 <sup>2</sup>
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	2	1	50.0	2400.0	1200.0	50.0
Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон өрх	1	5	5.0 <sup>2</sup>	1200.0	6000.0	5.0 <sup>2</sup>
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн		2			2400.0	
<b>4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал</b>						
